

“МОНГОЛ УЛСЫН ХУРААНГУЙ ТҮҮХ”

Харнууд З.Лонжид

Оршил

Монгол улсын Судар бичгийн хүрээлэн 1921 онд байгуулагдсанаас эхлэн хэд хэдэн чиглэлээр судалгаа хийх болсны дотор эх түүхээ үнэн, бүрэн боловсруулахад түлхүү анхаарч түүхэн дурсгалт зүйлс буюу янз бүрийн ном, гэрийн үеийн бичмэл, угийн бичиг, өргөмжлөл зэрэг сурвалж баримтыг 1925 он хүртэл тусгай төсөв, зардал гаргаж төлөвлөгөө боловсруулан хязгаар нутгаас эхлээд төвийн хэд хэдэн аймаг хошуудад хүмүүс илгээн цуглуулж байлаа. Үүнээс гадна улирч өнгөрсөн түүхээ өргөн олонд танилцуулах зорилгоор судалгаа, сурталчилгааны хураангуй өгүүлэл, тэмдэглэл, дурсамжийг 1922 оноос эхлэн зарим хүмүүсээр бичүүлж хэвлэн үнэгүй тархааж байв. Жишээлбэл, Сангийн яамны тэргүүн сайд С.Данзангийн *“Монгол Ардын Нам анх үүссэн учир”* хэмээх товхимол хэвлэгдсэн ба С.Жамьян, Нямжав гүн нарын бичсэн хэд хэдэн хураангуй өгүүллийн эх архивт байдаг. Эдгээрийн заримыг нь тухайн үедээ алс хязгаарын хошууд, төв суурин газруудад тарааж байжээ.

МАН-ын Төв Хороо 1924 оноос *“МАН-ын номын сан”* хэмээх нэртэй тусгай цувралыг 1932 оны эх хүртэл хэвлүүлсэн байдаг. Энэ цувралын хамгийн анхных нь *“Монгол улсын хураангуй түүх”* хэмээх бэсрэг товхимол юм. Уул номын 67-р талд *“Үүнийг Ишдорж би орчуулан найруулж олон эрдэмтэн, абугай нарт толилуулсугай”* хэмээн бичсэн юм гэж тэмдэглэснээс үзвэл Ишдорж гэдэг хүн энэхүү номын зохиогч ажээ. Зохиогч Ишдоржийн тухай тодруулахаар хөөж үзвэл зарим мэдээ байна. Тухайлбал 1922 онд Засгийн газрын хурлаас Ишдорж гэдэг хүнийг *“Дунд сургуулийн захирал бөгөөд олон ухааны багшаар”* томилсон ба 1923 оны VIII сарын 3-нд Засгийн газраас ГЯЯ ба Монгол газар суугаа Буриад, Монголын хэрэг эрхлэх газарт албан бичиг хүргүүлж дунд сургуульд багшилж буй сургагч Ишдоржийн томилолтын хугацааг сонгосон тухай мэдэгджээ¹. Мөн 1926 оны 12-р сарын 2-нд түүнийг Германд суралцах хүүхдийн даргаар томилсон байна². Эдгээр мэдээнээс үзвэл Ишдорж хэмээгчийг Буриад Монголоос урьж авчран сургуульд багшлуулж байжээ. Тэрбээр багшлахын сацуу Монголын эх түүх сонирхож энэхүү номыг бичсэн бололтой.

Энэхүү номын агуулгын товч

Уул ном таван хэсэгтэй. Нэгдүгээр хэсэг нь “Монгол улсын эдүгээ буй орон нутаг ба түүнийг хэзээ, ямар улс эзлэн суусны тухай” (Тал 1-8) Хоёрдугаар хэсэг

¹ УТА 1-1-1736.25, т.249-250.

² УТА 1-2-146. т.229-230.

нь “Монгол улсын анх мандаж тулгур төр байгуулан дэлхий дахинаа алдаршсаны тухай” (Тал 9-18) Гуравдугаар хэсэг нь “Монгол улс буурч олон анги, хэсэг тасарсан, бас хоорондоо эв найрамдлыг алдсаны тухай” (Тал 19-29) Дөрөвдүгээр хэсэг нь “Монголын төр мөхсөн ба эрэлхэг ид, чадлаа умартсаны тухай” (Тал 30-39) Тавдугаар хэсэг нь “Монгол Хятад хоёрын эв эвдэрч харилцан дайсан болсны тухай” (Тал 40-54). Номын төгсгөлд “Монгол улсын түүхэнд орсон зарим хаад эзэд ба элдэв чухал явдал, зүйл гарсны он сарыг дэс дараалан бичсэн товчоо”. (Тал 54-69) хэмээх хэсэгт Хүннүгээс эхлээд 1915 оны 6-р сард Хиагт хотноо Орос, Монгол, Хятад гурван этгээдийн хурлаас Монголыг өөртөө эзэрхэх автономит эрхтэй улс болгон тогтоосон тухай зэрэг 43 үйл явдлыг тоочиж “дэвтэр доторхи утга учир, товчийг бүрнээ мэдье хэмээвээс Уйгур улсын хураангуй түүх, Хөх Монголын хөх туг бусад олон Монголын хуучин түүхийг олж үзвээс нэн сайн болов уу хэмээмүй” гэжээ.

Номын эхний хэсэгт Монгол язгууртны эзэмшиж байсан нутаг дэвсгэр маш уудам бөгөөд умар хязгаар нь Аргун мөрөн, Байгал далай, Танну-ын уул, өмнө зүгт Цагаан хэрэм, Түвэдийн ар дахь уулс тулна. Энэ нутгийг Чингисээс урд Түрүг, Хаминиган, Зөрчид зэрэг элдэв угсаатан удаа дараагаар эзэлж байсан бөгөөд тэдгээрээс “Үлэмж сүр бадруулан олонд алдаршсан нь Хүнэ буюу Сүннү хэмээх нүүдэл аймаг, Огуз Түрүг хэмээх улс VI зууны үеэс эхлэн мандаж даруй Хятадын дорно дахь Шар далайгаас Баруунаа Европ тив хүртэл суусан олон улсыг нэг мөсөн эзэлж” чадсан юм. Огуз Түрүгийн умар этгээдэд мөн түрүг угсааны Уйгур хэмээх оршиж тэр хоёр хороондоо тэмцэлдсээр Түрүгийг эзэлж шинэ улс байгуулаад нэг зуун жилийн дараа Хиргис, Хасаг хэмээх улсад эзлүүлж мөхсөн хэмээн өгүүлжээ.

Монгол нутагт эртний хөшөө, чулуу, булш, дарш байдгийг хиргисийн үүр гэдэг боловч үнэндээ Түрүгийн үүр юм. Бас орд харшийн эвдэрхий суурь нурсан хуучин балгадын үлдэгдэл ба толгой, мөчүүд нь гэмтэж эвдэрсэн чулуун хүний хөрөг дүрс зэргийн юм маш элбэг олддог. Эдгээрийн зарим нь бичигтэй бөгөөд түүнийг Европын эрдэмтэд уншсан байна. Тэр бичээс нь манай эртний түүхийн олдошгүй их гэрч болдог учир бүх дэлхийн эрдэмтэд монгол газрын хөшөөнүүдийг сонирхож үздэг. Тэдгээр хөшөөг VIII зууны эхээр байгуулжээ. Зарим хөшөөний бичиг нь Түрүг улсын Могиляны сүр алдрыг ихэд дуурсган дайн байлдаан ба цусан замыг хүчирхэгээр үүсгэсний төлөө жич: мөн үеийн Культегин ба Тоньюкүк хэмээх зоригт эрчүүдийн явдлын тухай өгүүлсэн хөшөө нь Хөшөө Цайдам хэмээх газар Хуучин (Хөгшин З.Л) Орхоны эрэг дээр байдаг гэжээ. Тоньюкүкийн хөшөө Нийслэл Хүрээнээс зүүн өмнө Налайх хэмээх газар бий. Эдгээр “хөшөөнүүдийн дотор бидний монголчуудыг Гучин Татар хэмээн дурдсан зүйл байх бөгөөд энэ нэр Ази тивийн бусад улсад алдаршсан нь бидний монголчуудаас Европ тивд цөмрөн орсныг мөн Татар улс хэмээн нэрийдсэн билээ. Гэтэл бас Хятадын Тан улсын түүх бичигт монгол хэмээн дурдсан нь буй учир Чингисийн тулгур төр байгуулахын урьд Монгол хэмээх нэр эрхбиш гарсан боловч дэмий алдаршсангүй даруй мартагдсан бололтой.” (Тал 8) гэж тэмдэглэсэн нь судлаачдын анхааралд өртөхүйц сонин мэдээ юмаа.

Тэмүжингийн төрсөн огноог 1155 оны орчим хэмээн дурдаад түүний эцэг Есүхэй баатар энгийн арван гэрийн дарга агсан хэмээн өгүүлж “Тэмүжин бээр тэр цагийн язгууртан ба эрхтнийг цуглуулж цэрэг болгон захираад...ах дүү нэгэн угсаатан аймгуудаа нэгтгэн тулгур улсыг анх байгуулж 1203 онд харьяат улсдаа Монгол хэмээх хуучин нэрийг шинэтгэн олгож бас 1206 онд эдүгээгийн Монгол болох газарт суусан олон аймаг улсыг дагуулан авч гүйцэлдүүлсний дараа Онон голын эрэг дээр Их хуралдааныг зарлаж өөрийн биеийг сайхи улсын эзэн (өргөмжилсөн) бөгөөд Чингис хаан цол хүлээсэн байна” (Тал 10-11) Түүний дараа зэргэлдээ орших Уйгур, Гууль, Тангуд, Хар Хятад, Дорно Хотон зэрэг улсыг маш түргэнээ удаа дараагаар дайлан дагуулж улмаар Зөрчидийн эзэлж бүхий умар Хятадад явж ихэд дийлээд жич баруун зүгт зорьж Перс, Грузи зэргийг цэргийн хүчээр эзлэн авч бас өмнө Орост орж байлдахад Оросын цэргүүд нь Монгол цэргүүдийг Калк голын эрэг дээр 1224 онд тосож харилцан маш хүчирхэгээр байлдсан боловч орос цэргүүд эрхгүй дийлэгдэж сандран ухарсан билээ.

“Монголчуудын морио залсан эл газар бүхнээ улс төр бүгд мөхөж хот балгад бүхэн эвдрэн сүйдэж хүн ард нь орж дагасаар даруй гурван тивийг эзэлсэн маш хүчирхэг их улсыг тогтнуулан чадсан, түүнээс урьд хожид тэр мэт цаглашгүй хүчирхэг уудам их улс байгуулсан нь хүн төрөлхтөнд эдүгээ хүртэл үзэгдээгүй бөгөөд тэр үесийн монголчуудын ид чадал эр зоригийг нийтээр гайхалцан биширдэг ажгуу” (Тал 12-13) хэмээн тэмдэглэжээ. Ишдорж бээр монголчуудын ид хав, эр зоригийг нэхэн дурссаны сацуу Чингисийн аян дайны үед олон хот балгад сүйрч улс орон мөхөж үгүй болсон мэтээр хэтрүүлэн өгүүлсэнийг өнөөгийн өндөрлөгөөс нэхэн шүүмжлэх нь зохисгүй боловч зөвтгөх боломжгүй билээ. Тиймээс ЗХУ-ын харьяат Ишдорж хэмээгч бээр монголчуудын олон үеийнхний бахархал болсон эзэн Чингисийг өрнө дахины зарим түүхчдийн гүтгэн гүжирдэж бичсэн зүйлийг үнэн бодитой мэтээр давтан донгодсон нь анхаарал татаж байна. Бодоход өндөр эрх мэдэлтэй хэн нэгний тулган шаардсаны дагуу тэрбээр ийнхүү бичсэн байж болзошгүй.

Энэ номд Чингисийн тухай сөргөөр өгүүлсэн зүйл Орос Монголд улам бүр газар авсаар 1962 оны намар туйлдаа хүрсэн боловч эрч хүч нь сааралгүй үргэлжилсээр 1990 оны цагаан морин жилийн хувьсгалтай золгож түр намжсан юм. Гэтэл Киргизийн зохиолч Чингиз Айтматов болон ОХУ-ын зарим судлаач, уран бүтээлчид эзэн Чингисийг элдвээр гоочилсоор байна. Эргэцүүлж бодоход Чингисийн үйл хэргийг монгол түмэнд харлуулж таниулсан хорьдугаар зууны анхны монгол ном бол Ишдоржийн зохиомжилсон энэхүү орчуулга бололтой.

Уул бүтээлд Өгэдэй, Гүег, Мөнх, Бат нарын тухай цухас дурдсаны дотор Өгэдэй хаан Орхоны хөвөөн дээрхи Уйгурын хаад сууж байсан газар Хар Хэрэм (Хүрэм гэхийг ташаарсан бололтой З.Л) хэмээх үзэсгэлэнтэй гоёмсог хот байгуулсныг Европын хүмүүс тэр үед үзэж шагшин магтсан байдаг. Батын захирсан монгол цэрэг гурван жилийн хугацаанд Орос улсыг бүрнээ дагуулж цааш давшин Польш, Унгар улсыг эзлээд эх нутагруугаа буцах болсны учрыг товч тайлбарлажээ.

Хубилай хаан 1267 онд Бээжингийн суурин дээр шинэ нийслэл бариулж 1271 онд Юань улс байгуулсныг тэмдэглэсний сацуу хожим нь “Хураан цогцлоосон

олон овог, язгуур, үндэстний харьяат ардын дотор угаас цөөн монголчууд улам улмаар тархсаар шингэж гээгдэхэд шахсан билээ” (Тал 19) хэмээн Монголын сүр хүчин буурсан шалтгааныг тайлбарлажээ. 1368 онд Тогоонтөмөр хаан Бээжингээс хөөгдөж уугуул Монголдоо буцсан тухай; XV зууны эхээр монголчууд баруун зүүн хэмээн хоёр хэсэг болж Зүүн Монголыг Тогоонтөмөрийн үр сад, Ойрад Монголыг “Махамуд хэмээгч маш шаламгай хүчин төгөлдөр эр” захирч улмаар тэрбээр “бүх Монгол улсыг өөрийн эрхэндээ нэгтгэж хураан чадсан бөгөөд түүний ач Эсэн хааны үед Ойрадын хүчин чадал нь аугаа ихэд мандаж” Хятадын эзэн хааныг олзолж байсан хэмээн дурдаад 1453 онд Эсэн нас эцэслэснээр бүх Монголын эрх дахин зүүн Монголчуудын гарт шилжсэн тэр үеийн хаадыг нийт олноор ойшоон хүлээсэнгүй “Бага хаад хэмээн нэрийдсэн” (Тал 22) юм гэжээ.

1470-1544 онд бүх Монголыг захирсан Батмөнх Даян хаан таалал болохынхоо өмнө өөрийн 11 хөвгүүндээ газар нутгаа хуваан өгснөөс хойш бүх Монголчуудыг нэгтгэж чадаагүй, харин ч зүүн Монгол нь 2 хуваагдсаны улмаас бүх Монгол 3 хэсэг болж умар нь Халх, өвөр нь дотоод, баруун нь Ойрад гэгдэх болов. Өвөр Монголын хаад нь Даян хааны ахмад хөвгүүнээс салсан тул бүх Монголоо эзэрхийлэн хураахыг хичээж байсан тухай болон Түмэдийн Алтан хан, Лигдэн нарын тухай энэ номд товч дурдаж Гэрсэнз бээр 7 хөвгүүндээ тус бүр нутаг хуваан өгснийг тэмдэглэжээ. Гэрсэнзийн ач Абатай Алтан хантай нэг үе хан сууж тэд Монголд бурхны шашин хэрхэн дэлгэрүүлсэн тухай дурджээ.

Мөн дөрвөн Ойрадын тухай тайлбарлаж тэдний эрх баригчид Хун тайж гэдэг цолтой байсан ба XVII зууны эхээр Ойрад задарч Хошуудын Гүүш, Торгуудын Хо өрлөг нар харьяатаа авч Хөх нуур ба Орос зүг одсоныг цаг хугацаа заан тэмдэглэсэн байна. 1640 онд Ойрадын тэргүүн Баатар хунтайжийн санаачлагаар Ойрад Халхын ноёдын хуралдаан болж Цаазын бичиг баталсныг тэмдэглээд урьд өмнө нь эвдрэлцэж байсан Ойрад халхын ноёд ийнхүү нэг дор цуглаж хуралдсан нь тухайн үед Манж улс хүчирхэгжиж бүх Монголыг эзлэхээр завдаж буйг мэдээд түүний эсрэг хүчээ нэгтгэн тэмцэх хэмээсэнтэй холбоотой гэжээ.

Гэвч Ойрад Халх хоёр эвлэрч чадсангүй Ойрадын Галдан бошогт хан 1670 оноос эхлэн Халх руу хэд хэдэн удаа довтолсны улмаас 1691 онд Халх Монгол Манжид дагаар оржээ. “Манж нар Халхыг Ойрадаас хамгаалж чадсан мэтээр мөн Ойрадын булаасан газар усыг эгүүлэн авч Халхад өгчээ” (тал 33) хэмээсэн нь үнэн эсэхийг тайлбарлах шаардлагагүй билээ.

Манжийн төр монголчуудаас алба гувчуур хураан авсангүй харин өртөө, цэрэг, харуулын албыг гүйцэтгүүлж байв. Гэвч ер цэрэг дайнгүй цаг тохиолдсон тул цэргийн алба төдий л хэрэггүй байлаа. Гагцхүү Бээжингээс томилогдон Монголд сууж байсан сайд түшмэл цөм ашиг шунал, хахууль бэлгийг хэтэрхий ихээр хураан авч ард түмнийг хохируулан зовоодог нь алба мэт болсон ба бас өртөө харуулын зэрэг албадын үүрэг маш хүнд байсныг цохон дурджээ. (тал 39) Манжийн төрөөс монголчуудын дунд бурхны шашин үлэмж ихээр дэлгэрүүлсний сөрөг үр дагаврыг Ишдорж бээр энэ номдоо шүүмжлэн тэмдэглэжээ.

Зохиолын сүүлчийн хэсэгт монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны учрыг тайлбарлаж “1911 онд Бээжингийн засгийн газраас ар Халхын газар усыг эзэрхэж харьяат иргэндээ үлэмжхэн хэмжээ бүхий газар олгож

нүүлгэн суулгах, бас Хүрээнд хятад цэргүүдийг олон болгохоор завдсан” зэрэгт монголчууд дургүйцэж Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан нарыг Хаант Орос илгээж Манжаас салахад туслахыг хүсэхэд “эзэрхэг засагт Орос улсаас ямагт Дорно зүгийн бага буурай улсыг эзлэн залгисугай хэмээсэн шунахай зорилготой тул” (Тал 41) дуртай зөвшөөрч “бас Бээжингийн засгийн газарлугаа шууд хятад иргэдийг монгол газар оруулж дур мэдэн газар усыг эзлүүлэхгүй болгохын тулд Орос Хятад хоёр улс хэлэлцээ эхлэн бүхий тэр цагт Хятад улсын бошгийг халах явдал гэнэтэд дэгдэн гарч монголчуудад их завшаан тохиолдсонд даруй шимтэж Нийслэл Хүрээний газар 1911 оны XI сарын 18-ны өдөр Монгол Улс болвоос Хятадаас салж тусгаар бүрэн эрхт улс болсон учрыг илтгэн” (Тал 45-46) зарлаад XII сарын 16- (Григорийн тооллоор XII 29)-ны өдөр Богд Жибзундамба хутагтыг төрийн тэргүүнд өргөмжилж хаан ширээнээ залсан тухай өгүүлжээ.

Монгол улс тусгаар тогтнолоо зарласнаас хойш Хаант Орос улс Монгол, Хятадын хооронд зуучлахыг санаархсан боловч Хятад улс хайхраагүй учир Орос, Монгол хоорондоо хэлэлцэж байгуулсан хэмээн бичээд тэрхүү гэрээний агуулгыг дурдаад ДИУ уул гэрээг эсэргүүцсэн боловч 1913 онд Оростой хэлэлцээ хийж “Монголыг Хятадын сюзеренитет хэмээх эрхэнд багтаах бөгөөд нутаг дэвсгэр нь хятадын нутаг дэвсгэр лүгээ нэг болно” (Тал 51-52) хэмээн тохиролцсоныг “эргэцүүлэн хянаваас манай Монгол улсын нэгэн биеийг эзэрхэг түрэмгий Орос ба Хятад улс харилцан хоорондоо сүлбээлдэн нууцаар хэлэлцэж манай монгол язгууртны нэгдэх зэрэг хэргийг үрэгдүүлэн Монголын ашиг тусыг хуваан авч мөлжихөөр тогтсон билээ. Тийнхүү манай бага буурай улс хоёр их эзэрхэг, хүчирхэг улсын хооронд дэмий тэнэж хөөрхийгээр мэхлэгдэн хохирсон ажгуу” (Тал 53-54) хэмээн дүгнэжээ. Энэхүү номын зохиогч Ишдорж бээр Монголын эх түүхийг Хүннүгийн үеэс эхэлж 1915 оны дунд үе хүртэлх хугацааг хамруулан хураангуй өгүүлэхдээ нилээд зүйлийг өрнийн судлаачдын бүтээлээс орчуулан ашиглажээ. Тэгэхдээ зохиогчдынх нь санааг аль болохоор өөрчлөхгүйг хичээсэн бололтой. 1911 оноос хойшхи хугацааны Монголын тухай бичихдээ албан ёсны гэрээ хэлэлцээрүүдийн эх баримтад тулгуурлаж өөрийнхөө байр суурийг илэрхийлжээ.

Эцэст нь тэмдэглэхэд энэ номыг дахин хэвлэж сонирхсон хүмүүст толилуулбал 1921 оноос хойшхи Монголын түүх бичлэгийн судалгаа хийхэд бага боловч тус болох нь эргэлзээгүй билээ.

Abstract: *The Central Committee of the People's Party of Mongolia published a special series called Biblioteca of the People's Party of Mongolia from 1924 until early 1932. The first number of this series was an introduction to the handbook Mongyol Ulus-un Quriyangyui Teske (Brief History of Mongolia) written by Ishdorj. It is certain that a detailed analysis of the handbook contributes to the study of post-1921 Mongolian historiography.*

